



Lantuun Dohio

UNITED AGAINST CHILD ABUSE & HUMAN TRAFFICKING

ЭРСДЭЛҮҮД

УХААЛАГ УТАСНААС ИЛҮҮ УХААЛАГ БАЙХ 5 АРГА!

ЭЦЭГ ЭХЧҮҮД УХААЛАГ УТАСНЫ ХЭРЭГЛЭЭГ ТАНИХ НЬ

**АШИГТАЙ АЮУЛТАЙ
ЮУ? ЮУ?**

Ухаалаг утсыг жижгэрүүлсэн компьютер гэж хэлж болох тул та хүүхдэдээ гар утас ашиглуулахдаа бага зэрэг болгоомжилж байж магадгүй. Ухаалаг утасны хэрэглээтэй холбоотойгоор учирч болох эрсдэлүүдийг таньж, тэдгээрээс хамгаалах аргуудыг хэрэгжүүлэн хүүхдээ дэмнээрэй.

• ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛТ

Хүүхэд ухаалаг утсаар дамжуулан цахим орчинтой тасралтгүй холбоотой байснаар цахим дээрэлхэлд илүүтэй өртөх эсвэл бусдыг цахимаар дээрэлхэх магадлалтай.

• БАЙРШИЛ ТОГТООГЧ

Байршил тогтоогч нь ажиллаж байгаа ухаалаг утас хүүхдийг тань хаанаас нийтлэл болон зураг оруулж буйг нийтэд дэлгэх эрсдэлтэй.

• ЗОХИСГҮЙ КОНТЕНТ

Таны хүүхэд порно эсвэл хүчирхийллийг ил тод харуулсан бичлэгүүдийг ухаалаг утсан дээрээсээ хаана ч явсан үзэх боломжтой.

• СЕКСТИНГ

Хүүхэд тань биеийнхээ эмзэг хэсгийг ил гаргасан зургийг интернэт болон нийтийн сүлжээгээр бусдад илгээх эсвэл бусдаас хүлээн авах, дамжуулах эрсдэлтэй.

• ВИРУС

Хэрвээ хүүхэд тань хамгаалалтгүй вэбсайт болон аппликейшнд хандвал ухаалаг утас нь яг л компьютерын адил халдлагад өртөмтгий байна.

1.Эцэг эх бас эх сурвалж нь байгаарай.

Ухаалаг утас ашиглах цагийн хязгаар тогтоох, интернэт орчинд зохисгүй авир гаргавал ямар сөрөг үр дагавартай талаар тодорхой зөвлөгөө өгөхөөс гадна хүүхдэд тань ямар нэгэн асуудал гарч тань дээр хүрч ирвэл нээлттэй байгаарай.

2.Ухаалаг аюулгүй байдлын тохиргоог ажиллуулаарай.

Ухаалаг утаснуудад царай таних, хурууны хээ унших, нууц үгээр нэвтрэх гэх мэт олон төрлийн хамгаалалтын механизмууд бий. Эдгээрийг ашиглан утсаа болон хувийн мэдээлэл ихээхэн агуулдаг аппуудаа түгжээрэй.

3.Үйлдлийн системээ шинэчилэх.

Үйлдлийн системийн шинэчилсэн хувилбарт аюулгүй байдлыг улам бүр сайжруулсан байдаг.

4.Апп-ыг утсандаа суулгахаасаа өмнө хянах

Тухайн аппыг ямар зориулалттай болон ямар мэдээ мэдээллээр хангадгийг мэдэж байж утсандаа суулгаарай.

5.Байршил тогтоох үйлчилгээг ойлгох

Газрын зураг ашиглаж байх үед байршил тогтоогч хэрэгтэй хэдий ч цахимаар нийтлэл оруулах үедээ өөрийн байршилыг хавсаргах тохирогоог унтраагаарай.



NetSmartz®

